

Буддын танин мэдэхүйн онолын (prama) тайлбарлалын уламжлал

Баасанжавын Ариунзул, докторант

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

ariunzulb@mas.ac.mn; <https://orcid.org/0000-0002-0226-489X>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-25

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

prama онол,
гурван эрэмбэ,
танин мэдэхүйн
онолын тайлбарлал,
эх сурвалжийн
фрагментууд

Keywords

prama theory,
three-tiered structure,
epistemological exegesis,
resource fragmentations

© The Author(s), 2024



Хураангуй: Танин мэдэхүй дэх объект, субъектын харилцаа, тэдгээрийн зүй тогтол, логик хамаарлыг шинжлэн боловсруулсан Дигнага, Дхармакирти нарын үзэл санааг хожим онолын бүтэц, зохион байгуулалтад оруулсан байдаг. Эдүгээ үүнийг буддын судлалд *prama* онол гэж нэрлэх болжээ. Тус онол гурван эрэмбэтэй бөгөөд Дигнага, Дхармакирти нарын эх сурвалж дахь бичвэрийг философийн нэмэлт аргументаар дэлгэрүүлэн тайлбарлах явцад ийнхүү загварчлагдсан байна. Prama онолын гурван эрэмбэ үзэл баримтлалын хувьд бүгд бие даасан онол мөн эсэх нь буддын эпистемологид хэлэлцэх нэгэн сэдэв болсоор иржээ. Үүнтэй холбогдуулж буддын эпистемологийн тайлбарууд дундаас Девендрабуддхигийн тайлбарлал хэрхэн уламжлагдан хадгалагдаж ирсэн талаар бид энд товч өгүүлэх болно. Ингэхдээ гол үндэслэл болж байгаа эш баримтыг Дхармакиртийн «Pramānavarttika»-аас товчлон авч, холбогдох бусад фрагментуудыг Гэлэгбалсангийн «Тийн тайлбарын их тайлбар», «Долоон аймгийн чимэг», Гэндэндүвийн «Зохист ухааны чимэг» зохиолуудаас түүвэрлэн авав. Үүнээс үндсэн шастарын өгүүлэмж, тухайн эх зохиолын тайлбарлал, түүний уламжлагдан хадгалагдсан байдал зэргийг харж болох юм.

Traditions of buddhist epistemological exercises

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, ariunzulb@mas.ac.mn

<https://orcid.org/0000-0002-0226-489X>

Abstract: The theory developed by Dignaga and Dharmakīrti, which analyzes the relationship between objects and objects in cognition and their logical patterns, is later incorporated into Buddhism's structured framework known today as Prama theory. This theory is divided into three levels, based on the resources of Dignaga and Dharmakīrti, and further philosophical arguments expand their ideas. One of the topics of debate in Buddhist epistemology is whether these three levels of Prama theory are independent or interconnected. In this paper, we will briefly examine how Devendrabuddhi's interpretation was preserved among other Buddhist epistemological interpretations. This paper is based mainly on the Pramavarttika of Dharmakīrti, supplemented by other relevant fragments, such as the rNam 'grel thik chen rigs pa'i rgya mtsho of Gelek Palsang and Tshad ma'i bstan bcos sde bdun gyi rgyan yid kyi mun sel of Gendun Drup. Through these texts, we can trace the development of the fundamental philosophical treaty, its original interpretation and its preservation over time.

I. Оршил

Дигнагийн (480-540) «Pramāṇasamuccaya (Шалгадаг хотлоос түүсэн)» бол логик, эпистемологийн сэдвүүдийг зургаан бүлэгт багтаан, товч авч үзсэн буддын шалгадаг ухааны үндсэн шастар юм. Тус шастарт Дигнага өөрөө тайлбар^{6*} хийснээс гадна Дхармакирти (600-660),^{7*} Жинендрабуддхи (710-770)^{8*} нарын сэтгэгчид тайлбар зохиосон байдаг. Дхарматирки Дингагийн зохиолын агуулгыг дөрвөн бүлэгт хураан багцалж тайлбарлажээ. Тус тайлбар түүний шалгадаг ухааны чиглэлээр бичсэн гол зохиолуудын нь нэг юм. Үүнд нь түүний шавь, шавийн шавь болон үзэл баримтлалыг нь дэмжин хөгжүүлэгчид болох Девендрабуддхи (630-690),^{9*} Шакъябуддхи (VIII зуун),^{10*} Пражнакарагупта (IX зуун)^{11*} нар мөн тайлбар хийсэн байдаг. Эдгээр зохиолуудыг уламжлалын дагуу дараа дараагийн үед мөн л тайлбарласаар иржээ. Тухайлбал, Пражнакарагуптагийн «Шалгадгийн тийн тайлбарын чимэг»-т хожим Жина (XI зуун) тайлбар зохиосон нь «Pramāṇavārttikālakāra-ṭika (Шалгадгийн тийн тайлбарын чимгийн тайлбарномлол)» юм. Энэ бүхэн зөвхөн «Pramāṇasamuccaya», түүний анхны үндсэн тайлбар «Pramāṇavārttika»-д холбогдох тайлбаруудын нэгээхэн хэсэг юм. Энэтхэгт буддын логик, танин мэдэхүйн онол ийнхүү анхны

эх бичвэрийн үг, утгыг тодотгон дэлгэрүүлж, үргэлжлүүлэн дахин давтан тайлбарлах замаар олон зууныг дамжин хөгжжээ. Үүсэл хөгжлийн энэхүү явцдаа өөр шинэ философийн аргуудтаар нэмэгдэн баяжсаар ирсэн байна.

Төвдөд үүсч хөгжсөн буддын танин мэдэхүйн онолыг хуучин, шинэ гэх хоёр үе шатанд хуваадагтай зарим судлаачид санал нийлдэггүй. Энэхүү үечлэлд он цагийн дарааллаас гадна тухайн чиглэлийн ном зохиолын орчуулгын стандартыг гол шалгуур болгосон нь өрөөсгөл, субъектив хандлага гэж үзэж, хүлээн зөвшөөрдөггүй тал бий. Харин эхэн (IX зууны дунд хүртэлх) болон хожуу (X зууны II хагасаас хойших) үе гэж хуваасныг оновчтой ангилал гэж үздэг. Үүнд санскрит, пали болон хятад хэлээр дээрх буддын шалгадаг ухааны ном зохиолын орчуулга, судалгаа, тухайн үйл явцын өрнөл, идэвхжлийг гол үндэс болгожээ. Хожуу үеийн төвд хэлний орчуулгад их хэлмэрч Ог Лэгвийшэйрав, Ог Лоданшэйрав нар онцгой үүрэг гүйцэтгэсэн учраас Огийн үе гэж зарим судлаачид нэрлэж, тэмдэглэсэн байх нь мэр сэр харагддаг. Баримтаас харахад шалгадаг ухааны зохиолууд, тэр дундаа гол гол тайлбаруудыг төвд хэлээр орчуулан дэлгэрүүлэх таатай нөхцөл энэ үед бүрдсэн байна. Үүний үр дүнд хожуу дэлгэрэлтийн үед Девендрабуддхи, Дхармоттара (750-810), Пражнакарагупта нарын

⁶ *Dignāga. Pramāṇasamuccaya-vṛtti (Tshad ma kun las bstus p'i 'grel pa/ Шалгадаг хотлоос түүсний тайлбар).

⁷ *Dharmakīrti. Pramāṇavārttika (Tshad ma rnam 'grel/ Шалгадгийн тийн тайлбар).

⁸ *Jinendrabuddhi. Pramāṇasamuccaya-ṭikā (Tshad ma kun las bstus p'i 'grel bshad/ Шалгадаг хотлоос түүсний тайлбар номлол).

⁹ *Devendrabuddhi. Pramāṇavārttika-pañjika. (Tshad ma rnam 'grel gyi dka' 'grel/ Шалгадгийн тийн тайлбарын бэрхийг тайлсан тайлбар).

¹⁰ *Śākyabuddhi. Pramāṇavārttika-ṭikā (Tshad ma rnam 'grel gyi dka' 'grel bshad/ Шалгадгийн тийн тайлбарын тайлбар номлол).

¹¹ *Prajñākaragupta. Pramāṇavārttikālakāra (Tshad ma rnam 'grel gyi rgan/ Шалгадгийн тийн тайлбарын чимэг).

танин мэдэхүйн онолын тайлбарлалын гурван гол уламжлал төвдийн хөрсөнд нутагшсан (Leonard W.J. van der Kuijper, 1983, 2) гэж судлаачид дүгнэдэг.

Ийнхүү буддын шалгадаг ухаан төвдөд хөгжихөд орчуулгын уламжлал онцгой байр суурьтай байв. Түүнийг дагалдан төвдүүд онол, сургаалыг тайлбарлах арга, дэг горимыг ч хүлээн авч, хөгжүүлснээр Дигнага, Дхармакирти нарын эх зохиолууд, тэдгээрийн тайлбаруудыг өөрсдөө судлан тайлбарлах, нэг сэдэвт зохиол бүтээн туурвих ажлыг эрчимтэй өрнүүлжээ. Гэхдээ энэ бол төвд хэлт буддын шалгадаг ухаан бүрэлдэн хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйлсийн нэгээхэн хэсэг гэдэг нь тодорхой. Төвд хэлээрх буддын шалгадаг ухааны ном бүтээл асар их. Зөвхөн Дармакиртийн «Pramānavārttika»-д хийсэн тайлбар зохиолууд гэхэд л нэлээд бий. Тухайлбал, Жамьяншадавын «Шалгадгийн тийн тайлбарын магадлан шинжлэл (*Tshad ma rnam 'grel gyi mtha' gcod*)»; Жамьянчоглха-Одсэрийн «Шалгадгийн тийн тайлбарын хураангуй шүн (*Tshad ma rnam 'grel gyi bsdus gzhung shes bya 'i sgo 'byed rgol ngan glang po 'joms pa gdong lnga 'i gad rgyangs rgyu rig lde mig*)»; Дармаринчэнгийн «Тонилох мөрийг чанх буруу бусаар тодруулагч нэрт Шалгадгийн тийн тайлбарын үгсийг бүлэглэн үйлдсэний тийн номлол (*Tshad ma rnam 'grel gyi tshig le 'ur byas p 'i rnam bshad thar lam phyin ci ma log par gsal bar byed pa*)»; Гэндэндүвийн «Шалгадгийн тийн тайлбарын сайн номлол (*Tshad ma rnam 'grel legs par bshad pa*)»; Гэлэгбалсангийн «Шалгадгийн тийн тайлбарын их номлол, зохист ухааны далай нэрт дэлгэрэнгүй шастар (*rgyas pa 'i bstan bcos tshad ma rnam 'grel gyi rgya cher*

bshad pa rigs pa 'i rgya mtsho)» зэргийг жишээлэн дурдаж болно. Эдгээрийг бусад ижил төрлийн ном сударт баталгаа, няцаалтын хэлбэрээр ихээхэн ашиглаж ирсэн байдаг. Тиймээс ч өнөө цагт онолын судалгаа, шинжлэлд голлон барьдаг чухал хэрэглэгдэхүүн болдог юм. Үүн дээр нэмээд тайлбарын тайлбар, мөн төвдүүдийн өөрсдийн нь бие даан туурвисан сэдэвчилсэн ном, бүтээл, тэдгээрийн тайлбарууд гээд барагцаалан тооцвол буддын шалгадаг ухааны үнэлшгүй, арвин сан хөмрөгийг бүрдүүлжээ.

II. Судалгааны арга зүй

Монголын буддын логик, танин мэдэхүйн онолын судалгааг өргөтгөх, зарим сэдвийг гүнзгийрүүлэн судлахдаа юуны өмнө удирдлага болох онолын үндэслэлээс гадна тухайн онолыг тайлбарлаж ирсэн уламжлалыг тодруулах шаардлагатай юм. Иймээс бид анхдагч эх зохиолын бичвэр болон түүнийг тайлбарласан эх сурвалжууд дахь фрагментуудаас түүвэрлэн авч харьцуулан шинжлэв. Ингэхдээ урьдаар ерөнхий тойм зураглал гаргаж, түүний дагуу утга тайлал хийн загварчлахыг урьтал болгосонгүй. Буддын судлал дахь тухайн асуудлыг философийн аль ёсонд хэлэлцэж, тайлбарлаж байна гэдгийг харгалздаг арга зүйн баримтлалд голлон тулгуурлав. Тус судалгаа нь цаашид буддын эпистемологи дахь судлагдахууны хүрээг тэлэх, гүнзгийрүүлэн өргөтгөхөд тус дөхөм болох болно гэж үзэж байна.

III. Үндсэн хэсэг

Өмнө дурдсан танин мэдэхүйн онолын тайлбарлалын уламжлалын хүрээнд олон зүйл яригдах болов ч энэ удаад дараах зүйлийг л тодруулъя.

Энэхүү уламжлал *prama* онолын тайлбарлал дээр тодхон харагддаг. Дигнага, Дхармакирти нарын эпистемологийн үзэл санааг хожим онолын бүтэц, зохион байгуулалтад оруулсныг одоо буддын судлалд *prama* онол гэж нэрлэх болжээ. Үүнийг төвд хэлт буддын утга зохиолд *шалгадаг, үрийн* онол гэж нэрлэдэг. Энэ онол ерөнхийдөө буддын эпистемологийн үндсэн шинж, дүр төрхийг тодорхойлдог юм.

Танин мэдэхүй дэх объект, субъектын харилцаа, тэдгээрийн зүй тогтол, логик хамаарлыг шинжлэн боловсруулсан Дигнага, Дхармакирти нарын үзэл санааг философийн нэмэлт аргументуудыг ашиглан дэлгэрүүлэн тайлбарласаар иржээ. Үүний үр дүнд гурван эрэмбэ бүхий *prama* онолын бүтэц загварчлагдсан байна. Ингэх явцад тус онолын гурван эрэмбэ үзэл баримтлалын хувьд бүгд бие даасан тусгаар онол мөн эсэх дээр тайлбарлалын зөрүү үүсчээ. Энэ нь буддын эпистемологид нэгэн хэлэлцэх сэдэв болж үргэлжилсэн байна. Ийнхүү ялгаатай байр сууриуд бий болж, үндсэндээ шалгадаг, үрийн онолын хувьд тайлбарлалын хоёр уламжлал тогтжээ. Үүний нэгд шалгадаг, үрийн онолыг гурван эрэмбэд бүлэглэж, зааглан тодорхойлдог бол нөгөөх нь үндсэн хоёр л эрэмбийг тогтоож үлдсэнийг нь нэмэлт тодруулгын үүргээр дагалдуулсан байдаг. Гэхдээ тайлбарлал бүхэн нь философийн нарийн үндэслэлүүдээр үндэслэгддэг. Энд эдгээрийг тоймлон харуулахын тулд тайлбарлалын уг сурвалж болж байгаа гол эш баримтыг Дхармакиртийн «Шалгадгийн тийн тайлбар»-аас товчлон авч, холбогдох бусад фрагментуудыг Хайдав Гэлэгбалсангийн «Тийн тайлбарын их

тайлбар», «Долоон аймгийн чимэг», Гэндэндүвийн «Зохист ухааны чимэг» зохиолуудаас түүвэрлэн авав. Үүнээс үндсэн шастарын өгүүлэмж, тухайн эх зохиолын тайлбарлал, түүний уламжлагдан хадгалагдсан байдал зэргийг харж болох юм. Гэлэгбалсан (1385-1438), Гэндэндүв (1391-1474) нарын дурдсан зохиолууд бол буддын шалгадаг ухааны чиглэлээрх нэг сэдэвт бүтээлүүд бөгөөд монголчуудын судалж, хэрэглэж ирсэн гол сурвалжуудын нэг юм.

[F1] (Дхармакирти. 2000)

Гадаад утга нь буй боловч хэр мэт мөнхүү анхааран амссан түүнийг магадлахын өвөрчилөнг өөрийн чанараар бус олны өвөрчлөний гэм буйн аман авсан боловч хоёул нугуудыг ангидаар амсах үл больюу. ...Ямар мэт зарим зүйл мэт, утга бод үгүйгээр үзэгдэлт тэр, хэр мэт утгыг барих хэмээвээс үнэн тэр мэтийг би бээр ч мэдэх бус болой.

[F2] (Gelek Palsang. 2009)

Гутгаар үрийг шинжлэхүй буй бөгөөд түүгээр сэтгэл төдийтний бусдыг ухахуйн шалгадаг, үрийг дэлгэрэнгүйгээр үзүүлсэн болой

Фрагмент [F2]-оос Хайдав Гэлэгбалсан «Тийн тайлбарын их тайлбар»-таа Девендрабуддхигийн байр суурь, хандлагыг тодорхой үзүүлснийг харж болохоор байна. Мөн Девендрабуддхи шалгадаг, үрийн онолын асуулуудыг эх сурвалжид өгүүлсэн дарааллаар нь гурван эрэмбэ болгож оноон жигдэлсэн нь ч тодорхой харагдана. Ингэхдээ тэрээр нэмэлт аргументуудад тулгуурлан философи тайлбарлал хийжээ. Харин гуравдугаар эрэмбийн онолыг тогтооход гол үндэслэл болж байгаа эхний фрагментаас үзвэл, дэс дугаар

үгүйгээс гадна сэтгэл төдийтний эсвэл судартны үзэл баримтлалын алин болохыг яг таг илэрхийлэх тодорхой үндэслэл, нотлол илт анзаарагдаггүй. Энэхүү хэсэг өгүүлэмжийн үг, утгыг тайлж ойлгоход нэлээд бэрх. Энэ нь эндүү ташаа ойлгохын суурь нөхцөл болсноос гадна мөн саутрантика болон йогачара философийн аль алиных нь үзэл санааны үүднээс тайлбарлах болоолцоотой зэргээс үүдэж утгын олон янз тайлбар хийгдсээр иржээ.

[F3] (Gendun Drup. 2010, 133)

Түүнээс гадна түрдээ, гадаад утгыг зөвшөөрдөг судрын аймагтан лугаа нийтийн ёсонд *үрийг шинжлэхүйн анханг* үзүүлсэн амуй. Гадаад утга үлигдэхүүн мөнийг хориод мэдлийн өөрийн чанар болсон дүрс тэргүүтнийг үлигдэхүүн, мэдлийн өөрийн чанар болсон дүрс тэргүүтнийг ухахуйг үр гэх *үрийг шинжлэхүйн дэдийг*; гадаад утга үлигдэхүүн мөнийг хорихыг өөрийн няцалгаас нь үзүүлэхгүйгээр утгыг өгүүлэгч та нар утга хэмээн зөвшөөрдөг дүрс тэргүүтнийг үлигдэхүүн гэхийн цагт ч мэдлийн өөрийн чанар болсон дүрс тэргүүтнийг ухахуйг үрд оноох хэрэгтэй болой хэмээн *үрийг шинжлэхүйн гутгаарыг* үзүүлсэн бөлгөө.

[F4] (Gelek Palsang. 1966, 232) Одоо өөрийн ёсыг өгүүлэх бөлгөө. Түүнд ч:*Нэгдүгээр үрийг шинжлэхүй* буюу бусдыг ухахуйн шалгадаг, үр; *Хоёрдугаар үрийг шинжлэхүй* буюу өөрийг ухахуйн шалгадаг, үр; Мөнхүү тэр ойллогыг магад нотлох гурав.

Тэгвэл Гэндэндүв «Зохист ухааны чимэг»-ээ Девендрабуддхигийн тайлбарлалын уламжлалыг хадгалж, зохиолынх нь бүтцийн дагуу туурвин

бичсэнийг [F3]-аас тодорхой харж болно. Гэндэндүв шалгадаг, үрийн онолыг гурван тусдаа эрэмбээр авч үзсэн Девендрабуддхигийн тайлбарлалыг үргэлжлүүлжээ. Гэхдээ Девендрабуддхи гурав дахид *сэтгэл төдийтний бусдыг ухах* шалгадаг, үрийг авч үзсэн бол Гэндэндүв *гадаад утгыг үлигдэхүүн* гэх судартны ёсыг йогачара философийн үндэслэлээр дэлгэрүүлэн тайлбарлажээ. Иймээс тэрээр энэ эрэмбийн онолыг йогачарын философийн онол гэж дурдсан байдаг. Энэ бүхнээс дээр дурдсан утгын тайлбарын зөрүүг бэлхнээ харж болох юм.

Харин Хайдав Гэлэгбалсан [F4] *шалгадаг, үрийг* үндсэн хоёр онолын үүднээс тайлбарладаг уламжлалыг дагаж саутрантика болон йогачара философийн танин мэдэхүйн онолыг авч үзээд, гурав дахь хэсэгт дагалдуулах байдлаар ханджээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн хоёр эрэмбэ бий, үлдсэн нь хоёрдугаарх буюу сэтгэл төдийтний *өөрийг ухах* ёсыг бататган нотлох нэмэлт үндэслэл гэж үзсэн байна.

Дээр өгүүлсэн бүхэн *prama* буюу шалгадаг, үрийн онолын эрэмбэ дарааг тодорхойлсон мэт боловч угтаа эдгээр эрэмбийн философи тайлбар аль чиглэлийн үзэл санаанд үндэслэгдсэнийг тодотгож өгч байгаа юм. Гурав болон хоёр эрэмбэ гэдгийн цаана философи тайлбарлалын ялгаатай байр сууриуд яригддаг.

[F5] (Gelek Palsang. 2009, 232) Хөх өнгө тэргүүтэн үлигдэхүүн, түүний дүр ургаад түүнийг шинэ тутам хуурмаггүй мэдэх нь шалгадаг мэдэл, хөх өнгө тэргүүтнийг оносон нь үр хэмээгдэх мөн амуй. Энэ шалгадаг, үрийн ойллого нь судрын аймагтан, сэтгэл төдийтөн хоёулангийн

нийтийн ёс мөн бөлгөө. Судрын аймагтан, сэтгэл төдийтөн хоёул бээр хөх өнгийн дүр ургах үүднээс хөх өнгийг барих илт шалгадаг мэдлээр хөх өнгийг ононо хэмээн зөвшөөрдгийг учир.

[F6] (Gendun Drup. 2010, 114)

Дүрс үлигдэхүүн, өөрийн вишайн дүр ургаад дүрсэд шинэ тутам, хуурмаг үгүй мэдэл шалгадаг мэдэл, дүрсийг оносон шалгадаг мэдэл үр хэмээгдэх нь судрын аймагтан, сэтгэл төдийтөн хоёрын нийтээр зөвшөөрдөг шалгадаг, үр мөн амуй.

Дээрх фрагментууд нь хоёулаа *шалгадаг, үрийн* нэгдүгээр эрэмбийн онолд хамааралтай юм. Энэ мэт олон жишээний өгүүлэмжүүдээс харахад тус эрэмбэд хэлэлцэгдэж байгаа танин мэдэхүйн онолын асуудлууд нь саутрантика болон йогачара философийн нийтлэг үзэл санаанд үндэслэгдсэн ажээ. Энэ эрэмбийн хүрээнд анх боловсруулагдсан үзэл санааны тайлбарлалууд нь тогтсон нэг чигийг барьж уламжлагдан хийгдсээр иржээ. Иймээс бид түүнийг *ерөнхий онол* гэж нэрлэн, энэ үүднээс тус онолын логик бүтэц, үндсэн ойлголт, суурь зарчмуудыг судалж байна. Тэгвэл бас энэтхэг, төвдийн тайлбарлалын уламжлалаас хазайн өөрөөр авч үздэг тохиолдлууд байна. Тухайлбал, Зава Дамдин «...шалгадаг, үрийн ялгавар тэр нь үрийг шинжлэхүй анхан түүний үзүүлэгдэхүүний эрхин болсон судрын аймагтан нийт бусын тааллын дагуух шалгадаг, үрийн ялгавар мөн» (Зава Дамдин. 2012, 200) гэж, Дандар аграмба «Шалгадаг, үрийн ёс тогтсон гурван бүлэг буйгаас эхнийх нь судрын аймагтан лугаа нийтийн мөн, удаах хоёр нь сэтгэл төдийтөн нийт бусын ойллого» (Дандар аграмба.

2023, 186) гэж нэгдүгээр эрэмбийн эпистемологи асуудлыг голлон саутрантика философийн үүндээс үндэслэн тайлбарлажээ.

Хоёрдугаар эрэмбийн тухайд гэвэл, түүнийг йогачара философийн танин мэдэхүйн онол гэх Девендрабуддхигийн тайлбарлал зонхилон уламжлагджээ. Энэ нь өмнө дурдсан фрагментуудаас тодорхой харагдаж байгаа юм. Мөн Дандар аграмба ч «Дэд үрийг шинжлэхүй, сэтгэл төдийтөн нийт бусын шалгадаг, үрд *бусдыг ухагч илт мэдэл, өөрийг ухагч илт мэдлийн шалгадаг, үр* хоёр буй» (Дандар аграмба. 2023, 189) гэж судлагдахуун бүрээр нь зааж өгсөн байдаг. Гэхдээ бас өөр аргументад түшиглэн өөрөөр тайлбарласан ч байдаг.

[F6] (Gelek Palsang. 2009, 233) Хоёрдугаар өөрийг ухахуйн шалгадаг, үр нь баригдах дүр үлигдэхүүн, түүнийг хуурмаггүй барих дүр шалгадаг мэдэл, өөрийг ухахуйг үр хэмээдэг амуй. Энэ өөрийг ухахуйн шалгадаг, үрийг ч судрын аймагтан, сэтгэл төдийтөн хоёул зохилдонгуйгаар зөвшөөрдөг бөлгөө. Судрын аймагтан, сэтгэл төдийтөн хоёул нэг оюуны барих дүр нь тэр оюуны баригдах дүрээс хамаарах бөгөөд өөрийг ухахуй илт мэдэл мөн хэмээн зөвшөөрдгийн учир болой.

[F6] фрагментад Гэлэгбалсан хоёрдугаар эрэмбийн онолыг *өөрийг ухахуй* гэж томъёолсон ч йогачара болон саутрантика философийн үзэл санааны нийтлэг байр суурин дээр авч үзсэн нь шүүмжлэлт тайлбарыг дагуулдаг.

IV. Дүгнэлт

Энд эш баримтаа болгосон зохиолуудыг, ялангуяа «Долоон аймгийн чимэг», «Зохист ухааны чимэг» хоёрыг шалгадаг, үрийн онолыг бүтцийн хувьд дараалуулан эрэмбэлэхэд үүссэн зөрүүтэй байр суурийг ерөнхийд нь харуулах үүднээс сонгосон юм. Ер нь бол энэ онолын талаар авч үзсэн маш олон зохиол бий. Тухайлбал, Жалцав Дармаринчэн Дхармакиртийн зохиол дахь дурдсан өгүүлэмжийн утгыг шинжлээд шалгадаг, үрийн гуравдугаарх нь судрын аймагтны ёс мөн гэж дүгнэсэн байх жишээтэй.

Ер нь буддын шалгадаг ухаанд шалгадаг, үрийн онолын гурван эрэмбийг нийтлэг хүлээн зөвшөөрдөг. Харин эрэмбэ бүрд яригдаж байгаа

эпистемологи асуудлуудыг тайлбарлах философи үндэслэлээс хамааран өөр өөрөөр томъёолж, тайлбарлаж иржээ. Анхдагч эх сурвалжийн бичвэрүүдэд хандахдаа тухайн бүлэг хэсэгт ямар үзэл санааг товойлгон илэрхийлэхээс хамааран нотолгоо эсвэл няцаалтын аргуудыг сонгон хэрэглэсэн нь ийнхүү тайлбарлалын ялгаатай байдлыг үүсгэсэн байна. Гэхдээ танин мэдэхүйн объект, субъектын харилцааны онолын гурван эрэмбийн эхнийхийг саутрантика болон йогачара философийн нийтлэг, ерөнхий онол, удаахыг йогачара философийн, сүүлийн үлдсэнийг саутрантика философийн тусгай онол гэх байр суурь давамгайл байна.

Ашигласан материал

- Leonard W.J. van der Kuijp. 1983. *Contributions to the development of Tibetan Buddhist epistemology (from the eleventh to the thirteenth century)*. Wiesbaden, Steiner.
- Дхармакирти. 2000. *Шалгадгийн тийн тайлбар. //Шалгадгийн долоон шастар (Буддизмын эх сурвалжууд II)*. Эрхэлсэн. Лувсанцэрэн Г. Улаанбаатар:
- Gelek Palsang. 2009. *rNam 'grel thik chen rigs pa'i rgya mtsho/ (Зохист ухааны далай нэрт Тийн тайлбарын их тайлбар)*. Lhasa, Tibet .
- Gendun Drup. 2010. *Tshad ma'i bstan bcos chen mo rigs ba'i rgyan (Зохист ухааны чимэг нэрт шалгадаг ухааны их шастар)*. Scanned at TBRC.
- Gelek Palsang. 1966. *Tshad ma'i bstan bcos sde bdun gyi rgyan yid kyi mun sel/ (Долоон*

аймгийн чимэг, сэтгэлийн мунхгийг арилгагч нэрт шалгадаг ухааны шастар). Delhi.

- Зава Дамдин. 2012. *Оюун ухааны шинжлэл, гайхамшигт сайн номлолын оньсон толь. //Түүвэр зохиол (эх бичгийн эмхэтгэл)*. орч. Алтансүх Р. Улаанбаатар: ШУА, Философийн хүрээлэн.
- Дандар аграмба. 2023. *Мадхьямакын гэгээ шастарын тэмдэглэл. //Философийн зохиолууд*. ред. Янжинсүрэн С. Ариунзул Б, орч. Алтансүх Р. Улаанбаатар: ШУА, Философийн хүрээлэн, “Адмон” ХХК.
- Hugon, Pascale. *Tibetan esistemology and Philosophy of language*. //http://plato.stanford.edu/entries/epistemology-language-tibetan/